



“СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ” УТУГ-ЫН ДАРГА
Г.ЭНХБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/334
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Соёлын өвийн төв” УТУГ-ын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Соёлын өвийн төв” УТУГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

В. 921

Ц.НАРАНЧИМЭГ

УХА-0122

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\20170224SAG1.Docx

0103384



“СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ” УТҮГ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын САГ-ын дарга Тэргүүлэх
аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахимхаяг:

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахимхаяг:

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахимхаяг:
serjmyadagb@audit.gov.mn

“Их-наяд аудит” ХХК
Байршил: БЗД 1-р хороо
ХХААХҮХолбоо 201 тоот
Утас: 99125283, 99077062
Цахим хаяг: ikhnayad-audit.mn

2016 оны 2 дугаар сар

Аудитынтайлан

Хавсралт 1: Аудитын тайлан

Хавсралт 2: Аудитынгэрчилгээний санал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйлажиллагаа
4. Аудитын шалгуур зүүлэлт, аудитынарга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Соёлын өвийн төв” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийнхэнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад үүнийг төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Соёлын өвийн төв” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Соёлын өвийн төв” УТҮГ нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС - тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Соёлын өвийн төв” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 22-ноос 2017 оны 2 дугаар сарын 10-ны хооронд хийхээр төлөвлөн “Их Наяд Аудит” ХХК-н аудитор Б.Дарьцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Соёлын өвийн төв” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 20-нд “Их Наяд Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Их-наяд Аудит” ХХК нь аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 22-ноос 2017 оны 2 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 20-нд Соёлын өвийн төв УТҮГ-ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Соёлын өвийн төв” УТҮГ-ын төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох журмын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, үүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Соёлын өвийн төв” УТҮГ нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1988 оны 148 дугаар тогтоолоор Музей удирдах газрын харъяанд үүх, соёлын дурсгал түүн дотроо музейн үзмэрийг мэргэжлийн түвшинд сэргээн засварлах үүрэг бүхий “Музейн үзмэр сэргээн засварлах урлан” нэртэйгээр байгуулагдаж, Дүрслэх урлагийн музейн нэгэн өрөөнд суурь нь тавигдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 302 дугаар тогтоол, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 47 дугаар тушаалаар Соёлын өвийн төв УТҮГ байгуулагдсан байна. Мөн уг тогтоолоор Соёлын өвийн төв УТҮГ-ын бүтэц, орон тоог нэмж, соёлын биет буюу бүтцийг судлах, хадгалж хамгаалах, бүртгэн дамжуулах, биет бус соёлын өвийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүрэг нэмэгдэн, үйл ажиллагаа нь өргөжсөн байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрхүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Соёлын өвийг хамгаалах тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Соёлын өвийн төв” УТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох үргэлжийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох үргэлжийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Соёлын өвийн төв” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын үүрэг тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 29-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох үргэлжийн бодлого, системтэй танилцахад “Соёлын өвийн төв” УТҮГ-ын БСШУСЯ-ны Сайдын 2013 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/465 дугаар тушаалаар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох үргэлжийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

“Соёлын өвийн төв” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан үүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Соёлын өвийн төв” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Аcolous санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлан гаргасан байна.

Материаллаг байдал

“Соёлын өвийн төв” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд аудит гүйцэтгэхэд материаллагын түвшинг 369,6 сая төгрөгийн нурсгал үйл ажиллагааны санхүүжилтын 1,0% буюу 3,7 сая төгрөгөөр тогтоон аудитын сорилуудыг гүйцэтгэхэд материаллаг хэмжээний зөрчил гараагүй болно.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж зсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн нүртурш нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм

“Соёлын өвийн төв” УТҮГ-ын санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын системтүүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг хуваарийн дагуу БСШУСЯ-ны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

“Соёлын өвийн төв” УТҮГ нь 2016 оны БСШУСЯ-наас батлагдсан төсвөөс 628,5 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөнөөс гүйцэтгэлээр 627,0 сая төгрөгийн санхүүжилт олгож үүнээс зардлыг гүйцэтгэлээр 795,0 сая төгрөгийг зарцуулж 166,5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

2014 оны 7 дугаарсарын 01-ний өдөрбатлагдсан “Шилэнданснытухай” хуульбатлагдан2016оны үгээрсарын д 01 -ний өдрөөсэхлэндагажмөрдөхөөрзаасанбаСоёлын өвийн төв ньшилэнданснызохионбайгуулалтанд2016оны1дугаарсарын10-наасорсонбөгөөд холбогдох мэдээллийг цаг тухайгүй оруулан ажилласан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 29 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Соёлын өвийн төв ” УТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайланматериаллагхэмжээнийалдаатайилэрхийлэгдээгүйгэдгийг, түүнийгбэлтгэнгаргахадбаримталсанбодлого, зарчмуудыгүнэлж, аудитынявцадсанхүүгийнтайланднөлөөлөхүйцхэмжээнийбүхажилгүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыгтүүвэрчлэннарийвчилсансорилынаргааршалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэнголзөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаархөндөгдсөнголасуудал гараагүй байна.Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй.

Залруулагдаагүй алдаануудынталаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Соёлын өвийн төв ” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэнаудитаарилэрсэнзөрчлийннэгтгэл:

“Соёлын өвийн төв ” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилтэй зүйл гараагүй байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Соёлын өвийн төв” УТҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланд “Их-наяд аудит” ХХК аудит хийж, аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Соёлын өвийн төв” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт болон илчлэл тодруулгад үйлдэгдсэн ажилгүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаа, үнэн зөв, шударгайлэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 5 хуудас хавсаргав.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
/ 2016 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН /

Санхүүгийн тайланд аудит хийх явцад аудиторын өмнө тавигддаг гол зорилго байгууллагын удирдлагаас үүсдэг тайлангаараа дамжуулан гаргаж ирдэг дараахь мэдэгдлүүдийг нотлоход оршдог:

1. *Оршин байх*: санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх;

Хөрөнгө, өр төлбөр, эзэмшигчийн өмч тухайн хугацаанд бодитойгоор оршин байх тухай мэдэгдэл юм. Энэ мэдэгдэл нь бараа материал, барилга, тоног өхөөрөмж, мөнгөн хөрөнгө зэрэг биет зүйлс төдийгүй дансны авлага, дансны өглөг зэрэг биет бус зүйлд хамаарна.

2. *Эрх ба үүрэг*: санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх;

Тодорхой өдрийн байдлаарх тухайн байгууллагын мэдээлсэн хөрөнгө нь түүний эрхийг, өр төлбөр/эх үүсвэр/ нь түүний үүргийг илэрхийлж буй гэдгийг баталсан мэдэгдэл.

3. *Тохиолдсон байх*: аж ахуйн нэгж, байгууллагад бүртгэгдсэн ажил гүйлгээ буюу үйл явдал нь тухайн тайлант хугацаанд бодитой болж өнгөрсөн байх;

Тохиолдсон байх гэдэг нь худалдан авалт, борлуулалт зэрэг бүртгэгдсэн ажил гүйлгээ нь тодорхой хугацааны явцад бодитойгоор болж өнгөрсөн буюу явагдсан эдийн засгийн үйл явдлыг илэрхийлж буй эсэхийг мэдэгддэг.

4. *Иж бүрэн байх*: аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас үүсдэггүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх;

Тодорхой хугацааны туршид болсон бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн бүх ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлууд нь бодитойгоор бүртгэгдсэн эсэхийг харуулсан мэдэгдэл. Жишээлбэл: худалдан авсан бүх бараа үйлчилгээ нь бүртгэгдсэн байхаас гадна санхүүгийн тайланд тусгасан байх ёстой.

5. *Үнэлгээ*: аж ахуйн нэгж, байгууллага одоогийн тайлангийн үзүүлэлтүүдийг тайлант хугацаанд "Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимтай" нийцүүлэн зөв үнээр бүртгэсэн байх;

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр үлээн зөвшөөрсөн зарчимд нийцүүлэн зөв дүнгээр бүртгэсэн эсэхийг энэхүү батламж мэдэгдэл илэрхийлнэ. Жишээлбэл: үндсэн хөрөнгийн тухайн жилийн элэгдлийн зардал болон үлдэгдэл үнийг түүний түүхэн өртгийг системтэйгээр хуваарилах аргадүндэслэн тооцсон болон худалдааны авлагыг тухайн өрөнгийн цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлснийг санхүүгийн тайлан харуулна.

6. *Хэмжилт*: аж ахуйн нэгж, байгууллага ажил үйлгээ буюу үйл явдал тайлант хугацаанд зөв дүнгээр бүртгэгдсэн ба орлого, зардлыг зөв хуваарилсан байх;

Байгууллага ажил үйлгээ буюу үйл явдлын гүйцэтгэлдүндэслэлтэй, үчинтөхөлдөрхэмжүүрхэрэглэж зөв дүнгээр бүртгэж, тайлагнасан эсэх талаарх мэдэгдэл юм.

7. *Толилуулга ба тодруулга*: аж ахуйн нэгж, байгууллагасанхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулж, тайлагнасан байх.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөв ангилж, тодруулсан эсэх талаарх мэдэгдэл. Жишээлбэл: урт хугацааг төлбөрийг барагдуулахдаа эргэлтийн өрөнгийг ашиглаж болохгүй ба бүртгэлийн бодлогын талаарх санхүүгийн тайлангийн хавсралт мэдэгдэл нягтлан бодох бүртгэлийн нийтээр үлээн зөвшөөрсөн зарчмаар шаарддаг тодруулгыг тусгасан байна.

8. *Үнэн зөв байдал*: аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх гэсэн батламж мэдэгдлүүдийг авч үзнэ.

Үнэн зөв байдлын талаарх мэдэгдэл нь санхүүгийн тайланд тусгасан бүртгэгдсэн ажил гүйлгээний математик тооцооллын зөв байдал болон эдгээр ажил үйлгээг зөв хураангуйлан ерөнхий дэвтэрт шилжүүлж бичсэнийг илэрхийлнэ. Жишээлбэл: дансны өглөг нь зөв үнэ ба тоо хэмжээ, зөв тооцоолсон нэхэмжлэлд үндэслэж бараа, үйлчилгээний худалдан авалтыг тусгасан гэдгийг санхүүгийн тайлан илэрхийлж байх ёстой.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	Өмнөх он	Тайлант он
Эргэлтийн хөрөнгө		
Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
Бусад авлага	238,500.00	9,079,500.00
Бичиг хэргийн материал	326,100.00	670,600.00
Аж ахуйн материал	116,460.00	171,580.00
Түлш, шатах тослох материал	-	-
Сэлбэг хэрэгсэл	100,000.00	100,000.00
Барилгын засварын материал	4,556,000.00	4,592,600.00
Бусад хангамжийн материал	57,248,267.03	57,639,247.58
Эргэлтийн хөрөнгийн дүн	62,585,327.03	72,253,527.58
Эргэлтийн бус хөрөнгө		
Биет хөрөнгө	723,350,738.60	565,663,744.50
Барилга байгууламж	16,900,000.00	16,900,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(5,430,000.02)	(8,810,000.06)
Авто тээврийн хэрэгсэл	282,000,000.00	282,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(130,694,444.81)	(164,986,111.36)
Машин, тоног төхөөрөмж	1,378,950,819.14	1,387,170,819.14
Хуримтлагдсан элэгдэл	(834,266,191.69)	(958,332,206.03)
Тавилга, аж ахуйн эд хогшил	57,425,786.03	57,425,786.03
Хуримтлагдсан элэгдэл	(45,133,601.05)	(49,314,914.22)
Номын фонд	3,598,371.00	3,610,371.00
Дуусаагүй барилга байгууламж		
Биет бус хөрөнгө	30,103,333.71	19,291,666.95
Програм хангамж	64,570,000.00	64,570,000.00
Хасагдуулга	(34,466,666.29)	(45,278,333.05)
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	753,454,072.31	584,955,411.45
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	816,039,399.34	657,208,939.03
Богино хугацаат өр төлбөр		
Бараа үйлчилгээний зардлын өглөг	191,370.00	
Бусад өглөг		7,875,000.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	191,370.00	7,875,000.00
ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ		
Эзний өмч		
Засгийн газрын оруулсан капитал	693,094,306.63	693,094,306.63
Өмнөх үеийн үр дүн	122,753,722.71	122,753,722.71
Тайлант үеийн үр дүн		(166,514,090.31)
Эзний өмч дүн	815,848,029.34	649,333,939.03
ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН	816,039,399.34	657,208,939.03

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Улсын төсвөөс	411,724,750.00	369,555,884.00
Хөрөнгийн санхүүжилт		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	411,724,750.00	369,555,884.00
Соёл урлаг хөгжүүлэх сангаас олгосон		
Нэмэлт санхүүжилтийн орлого	373,897,405.76	258,920,057.40
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		214,705,238.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого		14,986,219.40
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	355,560,396.76	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод захирагчид олгосон санхүүжилт	11,986,920.00	29,228,600.00
Төсвийн урамшуулал	6,350,089.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	785,622,155.76	628,475,941.40
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ	435,357,890.00	422,901,621.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	392,620,586.00	380,500,537.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	42,737,304.00	42,401,084.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	515,230,363.80	372,088,410.71
Байрны түрээс	25,146,000.00	21,476,000.00
Бичиг хэргийн материал	3,207,670.00	2,244,370.00
Тээвэр, шатахууны зардал	39,605,500.00	16,025,000.00
Шуудан холбооны зардал	2,654,866.19	3,522,002.90
Ном, хэвлэлийн зардал	20,000.00	
Бага үнэ түргэн элэгдэх зүйлс	197,880.00	121,430.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	260,000.00	591,800.00
Урсгал засварын зардал	5,111,040.00	3,741,600.00
Дотоод томилолтын зардал	15,775,800.00	19,832,300.00
Гадаад томилолтын зардал	4,267,800.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	191,730,031.71	102,735,573.00
Төрийн өмнөөс гүйцэтгэсэн үйлчилгээ	2,200,000.00	2,200,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	376,950.00	889,920.00
Тээврийн хэрэгслийн татвар	789,300.00	816,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	121,000.00
Газрын төлбөр	440,000.00	575,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	11,636,267.00	5,719,759.45
Хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлага	6,367,910.00	4,699,860.00
Элэгдлийн зардал	183,795,141.04	176,730,660.86
Төвлөрүүлэх шилжүүлэг	20,030,207.86	2,744,650.50
Биет хэлбэрээр	950,000.00	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		7,301,484.00
Нэг удаагийн тэтгэмж	580,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	950,588,253.80	794,990,031.71
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(164,966,098.04)	(166,514,090.31)
Үндсэн хөрөнгө худалдсаны олз	-	-
Бараа материал худалдсаны олз/ гарз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(164,966,098.04)	(166,514,090.31)

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	411,724,750.00	369,555,884.00
Улсын төсвөөс		
Хөрөнгийн санхүүжилт		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	411,724,750.00	369,555,884.00
Соёл урлаг хөгжүүлэх сангаас олгосон		
Тусламжийн орлого /гадаадын зээл тусламж/		
Нэмэлт санхүүжилтийн орлого	373,897,405.76	258,920,057.40
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	355,560,396.76	214,705,238.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод захирагчид олгосон санхүүжилт	11,986,920.00	29,228,600.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээн дэх		14,986,219.40
Төсвийн урамшуулал	6,350,089.00	
Нийтлэг татварын бус орлого	-	3,954,091.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,524,935.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		2,429,156.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	785,622,155.76	632,430,032.40
Цалин	392,620,586.00	382,929,693.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	42,737,304.00	42,401,084.00
Бичиг хэргийн зардал	3,533,770.00	2,660,270.00
Тээвэр, шатахууны зардал	39,605,500.00	16,025,000.00
Шуудан, холбооны зардал	2,463,496.19	3,713,372.90
Дотоод томилолтын зардал	15,775,800.00	19,832,300.00
Гадаад томилолтын зардал	4,267,800.00	
Ном, хэвлэлийн зардал	20,000.00	
Жижиг эд хогшил худалдан авах зардал	371,060.00	230,090.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	260,000.00	651,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	205,222,231.71	100,823,573.00
Төрийн өмнөөс гүйцэтгэсэн үйлчилгээ	2,200,000.00	2,200,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	615,450.00	651,420.00
Тээврийн хэрэгслийн татвар	789,300.00	816,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	121,000.00
Урсгал засварын зардал	5,111,040.00	3,741,600.00
Газрын төлбөр	440,000.00	575,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		1,524,935.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	6,653,910.00	4,699,860.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	20,030,207.86	11,824,150.50
Байрны түрээс	25,146,000.00	21,476,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		7,301,484.00
Нэг удаагийн тэтгэмж	580,000.00	
Биет хэлбэрээр	950,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	769,481,455.76	624,198,032.40
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	16,140,700.00	8,232,000.00
Хөрөнгө худалдаж авсан	16,140,700.00	8,232,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(16,140,700.00)	(8,232,000.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 12-р сарын 31 нээрх	693,094,306.63	-	122,753,722.71	815,848,029.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-		-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(166,514,090.31)	(166,514,090.31)
2016 оны 12-р сарын 31 нээрх	693,094,306.63	-	(43,760,367.60)	649,333,939.03

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280,333,700.00	280,317,334.00	16,366.00	99.99%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,436,800.00	31,436,046.00	754.00	100.00%
Байрны түрээс	21,476,100.00	21,476,000.00	100.00	100.00%
Бичиг хэрэг	523,400.00	148,840.00	374,560.00	28.44%
Тээвэр (шатахуун)	1,464,800.00	1,210,000.00	254,800.00	82.61%
Шуудан холбоо	2,387,600.00	3,015,512.90	(627,912.90)	126.30%
БҮТЭЗүйл	228,800.00	230,090.00	(1,290.00)	100.56%
Нормын хувцас зөөлөн эдлэл	665,500.00	651,200.00	14,300.00	97.85%
Урсгал засвар	3,270,700.00	2,241,600.00	1,029,100.00	68.54%
Дотоод томилолтын зардал	1,414,000.00	1,280,000.00	134,000.00	90.52%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	17,767,400.00	9,703,423.00	8,063,977.00	54.61%
Аудит	2,200,000.00	2,200,000.00	-	100.00%
Даатгалын үйлчилгээний төлбөр	815,000.00	651,420.00	163,580.00	79.93%
Тээврийн хэрэгслийн татвар	835,000.00	816,000.00	19,000.00	97.72%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	148,000.00	121,000.00	27,000.00	81.76%
Газрын төлбөр	575,000.00	575,000.00	-	100.00%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	4,712,600.00	4,699,860.00	12,740.00	99.73%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,310,700.00	7,310,700.00	-	100.00%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	377,565,100.00	368,084,025.90	9,481,074.10	97.49%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-	
Төсвөөс санхүүжих	377,565,100.00	368,074,809.90	9,490,290.10	97.49%
Урьд оны үлдэгдлээс			-	
Бусад төсөвт байгууллагаас			-	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	377,565,100.00	368,074,809.90	9,490,290.10	
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
Төвлөрүүлсэн шилжүүлэг				
Худалдаж авсан үндсэн хөрөнгө				
Төсөл арга хэмжээ				
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		